



о хоног түтмүн хэвлэл
ны 09 дүгээр сарын 19
№35 /704/

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

1428

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

1428

ТӨШЛЭГ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Орон сууцны цахилгаан
шатыг шинэчлэх тухай

Журам батлах тухай



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

350.	Төрийн өмчтэй хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах, балансаас балансад шилжүүлэх тухай	Дугаар 211	1425
351.	Орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх тухай	Дугаар 220	1428
352.	Журам батлах тухай	Дугаар 226	1428
353.	Дотоод хэргийн их сургууль байгуулах тухай	Дугаар 229	1431

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар сарын 6-ны өдөр	Дугаар 211	Улаанбаатар хот
--------------------------------------	------------	--------------------

Төрийн өмчтэй хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах, балансаас балансад шилжүүлэх тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчтэй хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр, балансаас балансад шилжүүлэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээ хийсний үндсэн дээр худалдах, балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР



Засгийн газрын 2011 оны 211 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ҮП ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

No	Үп хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Эзэмшигч хувулийн этгээдийн нэр
1	Ногооны зоорь	Дархан хот, Хонгор сумын 1 дүгээр баг	1995	5.622.806	"Дархан төмөрлөгийн үйлдвэр"
2	Конторын хуучин барилга	Дархан хот, Хонгор сумын 1 дүгээр баг	1991	2.000.000	"Дархан төмөрлөгийн үйлдвэр"
3	Цайны газрын барилга	Дархан хот, Хонгор сумын 1 дүгээр баг	1991	610.647	"Дархан төмөрлөгийн үйлдвэр"
4	Авто гучний байр	Дархан хот, Хонгор сумын 1 дүгээр баг	1994	10.000	"Дархан төмөрлөгийн үйлдвэр"
	Нийт үнэ			8.243.453	

Засгийн газрын 2011 оны 211 дүгээр
тогтоопын 2 дугаар хавсралт

**БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮП ХӨДЛӨХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Үп хөдлөх хөрөнгийн нэр	Байршил, нийт талбай	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төг)	Эзэмшиг хуулийн этгээдийн нэр	Шилжүүлсан авах хуулийн этгээдийн нэр
1	Шинжлэх ухааны академийн нэйдсэн 1 дүгээр байр (4 давхар барилга)	УБ хот БЗД-ийн 13-р хороо, Жуковын өргөн чөлөө, 2736 м ²	1971	2.189.096.495	Шинжлэх ухааны академийн харьяа Хэл зохиолын хурээлэн	Шинжлэх ухааны академийн харьяа Түүхийн хурээлэн
2	Цайны газар (1 давхар барилга)	УБ хот БЗД-ийн 16 дугаар хороо, Цэргийн 72 дугаар хоткон, 150 м ²	1970	11.250.000	Тагнуулын ерөнхий газар	Хил хамгаалах өрөнхий газрын 0288 дугаар анги
	Нийт үнэ			2.200.346.495		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар
хот

Орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх тухай

Сууц өмчлөгчийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын нийтийн зориулалттай орон сууцны байшингийн ашиглалтын хугацаа дууссан болон ашиглах боломжгүй болсон цахилгаан шатыг шинэчлэх нэг удаагийн арга хэмжээнд шаардагдах 20 (хорин) тэрбум төгрөгийг 2012 оны улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн цахилгаан шатны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 247 дугаар тогтоол, "Цахилгаан шат шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 248 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

Х.БАТТУЛГА

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 226

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Зайлшгүй шаардлагаар гадаад оронд эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр Эрүүл

мэндийн сайдын төсвийн багцад тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

3. Монгол Улсад одоогоор оношлох, эмчлэх боломжгүй өвчиний оношилгоо, эмчилгээг шинээр бий болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, эмнэлгийн нарийн мэргэжлээр эмч нарыг гадаадад мэргэшүүлэх, эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр зохих хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2011 оны 226 дугаар
тогтоолын хавсралт

**ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭНД САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Гадаад оронд зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) Эрүүл мэндийн сайдын дэргэд ажиллана.

1.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.4. Зайлшгүй шаардлагаар гадаад оронд эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг эрүүл мэндийн сайдын төсвийн багцад жил бүр тусгана.

Хоёр. Иргэдийн хүсэлтийг хүлээн авах,
шийдвэрлэх явц

2.1. "Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн жагсаалт"-д орсон өвчин, эмгэгтэй болохыг нь улсын хэмжээний үйлчилгээтэй төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлэг хяналтын комиссын зөвлөлгөөнөөс тогтоож, дүгнэлт гаргуулсан иргэн санхүүгийн дэмжлэг авах тухай хүсэлтээ эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавина.



2.2. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албаны гадаад орондоношилгоо, эмчилгээхийлгэх хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг хүлээн авч судлах, шаардлагатай бол холбогдох эмнэлгийн байгууллагаар нарийвчлан судлуулж саналаа Зөвлөлийн хуралд оруулна.

2.3. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар гаргасан Зөвлөлийн хурлын шийдвэрийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулж уг тушаалын хувийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

2.4. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу Сангийн яамны Төрийн сангийн газар эрүүл мэндийн сайдын төсвийн багцаас ажлын 5 өдөрт багтаан эмчлүүлэгчийн нэр дээр мөнгийг шилжүүлнэ.

Гурав. Иргэний хүлээх үүрэг

3.1. Гадаадад оношлуулах, эмчлүүлэх талаар эмнэлгийн дүгнэлт гарсан бол санхүүгийн дэмжлэг хүссэн иргэд өргөдлөө дараахь материалын хамт бүрдүүлэн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

3.1.1. иргэний үнэмлэхийн хуулбар, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

3.1.2. гадаад оронд оношлуулах, эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай болохыг тодорхойлсон төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлэг хяналтын комиссын дүгнэлт, дүгнэлтийг англи хэл дээр орчуулсан хувь;

3.1.3. хүлээн авч оношилгоо, эмчилгээ хийх талаар тухайн гадаад орны эмнэлгээс ирүүлсэн урилга буюу зөвшөөрөл;

3.1.4. зардлын бусад эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлсэн тухай мэдээлэл.

3.2. Гадаадад оношилгоо, эмчилгээ хийлгэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх иргэн дараахь шаардлагыг хангасан байна:

3.2.1. 5-аас доошгүй жил эрүүл мэндийн даатгалд тасралтгүй даатгуулсан байх;

3.2.2. Засгийн газрын нөөц сан болон улсын төсвееэс гадаадад эмчлүүлэх зориулалтаар зардал давхардуулан аваагүй байх.

3.3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлэг хяналтын комиссын дүгнэлт, сайдын Зөвлөлийн шийдвэргүйгээр өөрийн зардлаар гадаад улсад эмчлүүлсэн, санхүүгийн дэмжлэг олгох талаар Зөвлөлийн шийдвэр гарахаас өмнө нас барсан тохиолдолд зардлыг нехэн олгохгүй.

3.4. Гадаад оронд эмчлүүлэхээр явж байгаа иргэдийн тээвэр, байр, хоол, түүнчлэн дагалдан явах хүний зардал үүнд хамаарахгүй.

Дөрөв. Бусад

4.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар гаргасан шийдвэр, түүний дагуу зарцуулсан хөрөнгийн хэмжээ болон гадаадад эмчлүүлэгчдийн эмчилгээний дүнг Засгийн газарт жил бүр танилцуулна.

4.2. Иргэдэд олгосон хөрөнгийн зарцуулалтад холбогдох хуулийн дагуу хяналт тавина.

4.3. Эмнэлгийн дүгнэлт болон бусад материалыг хуурамчаар бүрдүүлж шийдвэр гаргуулсан этгээдээр олгосон төлбөрийг нехен төлүүлэх асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар
хот

Дотоод хэргийн их сургууль байгуулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 5.2, 5.5, 6.3 дахь хэсэг, "Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.2.13-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэрэг, тагнуулын салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Үндэсний тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургууль байгуулсугай.

2. Дотоод хэргийн их сургуулийн удирдлагыг 2011 оны 8 дугаар сард багтаан томилж, бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг батлан, Цагдаагийн академи, Үндэсний тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийн одоогийн байр, төсөвт түшиглэн үйл ажиллагааг нь зохих журмын дагуу эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

3. Дотоод хэргийн их сургууль байгуулсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт даалгасугай:

3.1. Цагдаагийн академи, Үндэсний тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуульд суралцаж байгаа оюутан, сонсогчдыг Дотоод хэргийн их сургуулийн холбогдох нэгжид шилжүүлэн хуваарилах ажлыг зохион байгуулах.

3.2. Цагдаагийн академи, Үндэсний тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийн багш, албан хаагчдыг Дотоод хэргийн их сургуулийн холбогдох нэгжид шилжүүлэн цол олгож дүрэмт хувцас, ажлын байраар хангах, багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулах.

3.3. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудад дотоод хэргийн чиглэлээр сургалт явуулдаг нэгж болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Гамшигийн сургалтын төвийг Дотоод хэргийн их сургуульд нэгтгэх ажлыг зохион байгуулах.

3.4. Дотоод хэргийн их сургуульд нэгтгэсэн сургууль, сургалтын байгууллагуудыг үүсгэн байгуулсан шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

3.5. Засгийн газраас хэрэгжүүлэх тесел, хетелбөрт Дотоод хэргийн их сургуулийг хамруулах замаар тус сургуулийн сургалтын хетелбөр, агуулга, чанарыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулах.

4. Дотоод хэргийн их сургуулийн төсвийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгаж тус сургуулийг их сургуульд тавигдах шаардлагад нийцүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан ажиллан багш нарыг мэргэшүүлэх, сургалтын орчинг сайжруулах чиглэлээр тесев, хөрөнгө тусгаж, дэс дараатай арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тагнуулын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 120 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ


Ханг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiiin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн худас 0.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487